

МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ХООРОНДЫН ХУДАЛДААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Н.Отгонсайхан*

Товч утга


Монгол улс, БНХАУ хооронд эдийн засаг, нийгэм, соёлын харилцаа өргөжиж, олон чиглэлээр хамтран ажиллах болжээ. Үүний илэрхийлэл нь сүүлийн жилүүдэд хоёр орны худалдааны эргэлт эрс нэмэгдэж, БНХАУ нь манай улсын гадаад худалдааны хамгийн том түнш болсон явдал юм. Энэхүү илтгэлээр Монгол улсын гадаад худалдаанд БНХАУ-ын эзлэх байр суурь, БНХАУ-д Монгол улсын нийлүүлэх боломжтой өрсөлдөх чадвар бүхий бараа бүтээгдэхүүн, цаашид хамтран ажиллах чиглэлийг тодорхойлохыг зорилоо.

Түлхүүр үг. Монгол улс, БНХАУ, гадаад худалдаа, экспорт, импорт, харьцангуй давуу тал

1. Монгол улсын гадаад худалдаа ба БНХАУ


Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд гадаад худалдаа чухал байр суурь эзэлж, өргөжин тэлсээр байна. Зах зээлийн шилжилтийн эхэн үед гадаад худалдаа уналтад орж 1991 онд өмнөх онтой харьцуулахад 2 дахин буурч¹ худалдааны эргэлт 708.9 сая ам.дол. болж байсан бол 2000 онд анх удаа 1.0 тэрбум ам.долларт хүрснээс хойш дэлхийн эдийн засгийн хямралын үеийг эс тооцвол тасралтгүй өсч, 2012 оны байдлаар 11.1 тэрбум ам. долларын худалдаа хийснээс экспорт 4384.6, импорт 6738.9 сая ам.дол. болсон.

* МУИС, Ph.D, И-мэйл: n_otgo@yahoo.com



Зураг 1. Монгол улсын гадаад худалдаа, сая ам.дол.

Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлтэд гол түнш орнууд болох БНХАУ, ОХУ, БНСУ, Япон, АНУ зэрэг улсууд 90 орчим хувь, эдгээр орноос Хятад улс сүүлийн жилүүдэд дангаараа 50 гаруй хувийг эзэлж байгаа юм. Түүнчлэн эдгээр орнуудад Монгол улсын нийт экспортын 90 гаруй хувь нь ногддог. Хятад улс нь Монгол улсын экспортын гол зах зээлд тооцогддог бөгөөд 2012 оны байдлаар дангаараа нийт экспортын 92.6 хувийг эзэлж байна (Зураг 2).



Зураг 2. МУ-ын экспортод Хятад улсын эзлэх хувийн жин, %

Гадаад худалдааны нийт эргэлтэд импортын эзлэх хувийн жин байнга өсөх хандлагатай байна. Монгол улсын гадаад худалдаа 1995 оны боловсруулах үйлдвэрийн сэргэлт, 2006 оны эдийн засгийн өсөлтийг дагуулсан экспортын барааны гадаад зах зээлийн үнийн өсөлтийн оргил үед хоёр удаа

ашигтай гарсныг эс тооцвол 1990 оноос хойшхи бараг бүх хугацаанд алдагдалтай гарсан байна. Хятад улстай хийж буй худалдааны тэнцэл эерэг байгаа хэдий ч нийт экспортод эрдэс бүтээгдэхүүн давамгайлж байгаа нь сайн үзүүлэлт биш юм.

Сүүлийн гурван жилд Монгол Улсаас БНХАУ-д экспортолсон барааны бүтэц, БНХАУ-ын импортын бүтцэд тухайн барааны эзлэх хувийн жинг дараахь хүснэгтэд харуулъя.

Хүснэгт 1. Монгол Улсаас БНХАУ-д хийсэн экспортын барааны бүтэц
(сүүлийн 3 жил, хувиар)

НС	Он	БНХАУ-д хийсэн нийт экспортод тухайн барааны эзлэх хувийн жин			Монгол Улсын нийт экспортод тухайн барааны эзлэх хувийн жин			БНХАУ-ын тухайн барааны импортод Монгол Улсын экспортын эзлэх хувийн жин			БНХАУ-ын нийт импортод тухайн барааны эзлэх хувийн жин		
		2010	2011	2012	2010	2011	2012	2010	2011	2012	2010	2011	2012
27	Эрдэс түлш, нефть ба тэдгээрийн бүтээгдэхүүн	46.9	49.8	54.0	39.4	43.5	48.6	0.6	0.7	0.7	13.5	15.8	17.8
26	Хүдэр, баяжмал	48.6	47.0	42.2	41.7	41.1	38.4	1.1	1.2	1.2	7.8	8.6	7.6
51	Ноос, мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгас	2.3	1.7	2.4	3.5	2.7	3.1	2.1	1.7	2.6	0.2	0.2	0.2
25	Давс; хүхэр; шороон эрдэс, чулуу; шаварлаг эрдэс	0.3	0.3	0.4	2.7	2.4	2.2	0.1	0.2	0.3	0.3	0.3	0.4


41	Арьс, ширэн түүхий эд (ангийн үснээс бусад), боловсруулсан арьс, шир	0.4	0.4	0.4	0.5	0.5	0.4	0.2	0.2	0.2	0.4	0.4	0.4
76	Хөнгөн цагаан ба түүгээр хийсэн эдлэл	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.0	0.0	0.1	0.6	0.6	0.5
Нийт		98.6	99.3	99.5	88.0	90.4	92.9	4.2	3.9	5.1	23.0	26.0	27.0

Дээрх хүснэгтээс үзэхэд, Монгол Улсын нийт экспортын 87 хувь, БНХАУ-д хийж буй экспортын 96.2 хувийг эрдэс баялаг, хүдэр, баяжмал эзэлж байхад БНХАУ-ын тухайн барааны нийт импортод Монгол Улсын экспортын эзлэх хувь дөнгөж 0.7-1.2 хувийг эзэлж байгаа нь хятадын тал манай экспортоос хамаарал султай байгааг харуулж байна.

Хятад улс уруу экспортолж буй барааны бүтцийг нарийвчлан авч үзвэл 2012 онд 21.7 сая тн. нүүрс (HS 2701), 535.5 мянган тн. зэсийн баяжмал (HS 2603), 499.2 сая тн. түүхий нефть (HS 2709), 6.3 сая тн. төмрийн хүдэр (HS 2601) 401.4 мянган тн. хүрэн нүүрс (HS 2702) экспортолсон.

Статистик мэдээллээс үзэхэд, 1999 оноос хойш дээрх гол түнш 5 оронд Монгол улсын нийт импортын 80 орчим хувь, үүний 30 орчим хувь нь Хятад улсад ногдож байна (Зураг 2).

HS	Нэр	2011 он		2012 он				
		Нийт импорт		сая.\$	%	сая.\$	%	БНХАУ-ын экспорт,%
		1898.4	100	2044.3	100			
85	Цахилгаан машин, төхөөрөмж, хэрэгсэл болон тэдгээрийн эд анги; дуу бичих, сэргээх төхөөрөмж, телевизийн дүрс, дуу бичих ба сэргээх төхөөрөмж, тэдгээрийн эд анги	445.8	23.5	487.5	23.8	24		
84	Цөмийн реактор, уурын тогоо, машин ба механик төхөөрөмж, тэдгээрийн эд анги.	353.8	18.6	376.0	18.4	18		
61	Сүлжмэл хувцас ба хувцасны сүлжмэл тоног хэрэгсэл.	80.2	4.2	87.1	4.3	4		
94	Тавилга; ор дэрний зөөлөн эдлэл, матрац, матрацны тулгуур, зөөлөвч ба тэдгээртэй төстэй гэр ахуйн чихмэл зөөлөн эдлэл; Бусад газар заагдаагүй гэрэлтүүлэгч, гэрэлтүүлэх хэрэгсэл; гэрлэн хаяг, гэрлэн самбар ба тэдгээртэй төстэй зүйлс; барилгын угсармал хийц.	59.3	3.1	77.9	3.8	4		
90	Оптик, гэрэл зураг, кино зураг, хэмжүүр, хяналт, нарийвчлал, эмнэлэг буюу мэс заслын багаж ба аппарат; тэдгээрийн эд анги ба тоног хэрэглэл.	60.7	3.2	72.8	3.6	3.5		
62	Оёмол хувцас ба хувцасны оёмол тоног хэрэглэл.	63.1	3.3	61.2	3	3		
73	Төмөр буюу гангаар хийсэн эдлэл	51.2	2.7	56.2	2.7	2.7		
39	Хуванцар болон хуванцар эдлэл	45.4	2.4	55.2	2.7	2.7		
87	Тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, тоног хэрэгсэл.	49.5	2.6	55.2	2.7	2.7		
64	Гутал, салдаг түрий болон түүнтэй төстэй зүйлс; тэдгээрийн эд анги.	41.7	2.2	46.8	2.3	2.3		
71	Жинхэнэ буюу таримал сувд, үнэт буюу хагас үнэт чулуу, үнэт металл, үнэт металаар бүрсэн жирийн металл, тэдгээрээр хийсэн зүйлс	27.5	1.4	45.5	2.2	2.2		
29	Органик химийн нэгдлүүд.	39.3	2.1	40.4	2	2		
Бүгд		1317.5	69.3	1461.8	71.5	69.1		



Зураг 3. МУ-ын импортод Хятад улсын эзлэх хувийн жин, %

Хятад улсаас 3000 гаруй нэр төрлийн бараа (БТКУС-ийн 8 орноор) импортолж байгаагаас машин, тоног төхөөрөмж, сүлжмэл хувцас (хүснэгт 2) нийт импортын 50 орчим хувийг эзэлдэг.

Хүснэгт 2. БНХАУ-аас импортолж буй барааны бүтэц

Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 50 гаруй, экспортын 90 гаруй, импортын 30 орчим хувь нь зөвхөн Хятад улсад ногдож байгаа нь манай улсын гадаад худалдаа Хятад улсаас ихээхэн хамааралтайг харуулж байна. Түүнчлэн Монгол улс эрдэс, түүхий экспортолж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнийг тус улсаас импортолж байгаа нь бүтцийн хувьд анхаарах шаардлагатайг харуулж байна. Иймд цаашид Хятад улсад нийлүүлэх боломжтой бараа бүтээгдэхүүнийг тодорхойлох хэрэгтэй юм.

2. БНХАУ-д Монгол улсын нийлүүлэх боломжтой өрсөлдөх чадвар бүхий бараа бүтээгдэхүүн

Олон улсын худалдааны онолоор бол аливаа улс орон өөрийн харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр төрөлжиж, тэрхүү харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүнээ худалдаалах нь үр ашигтай гэж үздэг ба эрдэмтэн Бела Баласса (Balassa, 1965) анх харьцангуй давуу талыг тодорхойлох индекс²-ийг ашиглах санааг дэвшүүлсэн. Энэ индексийн тусламжтайгаар бид түнш орнууддаа ямар бүтээгдэхүүнийг нийлүүлэх, тэднээс юу худалдан авах боломжтой эсэхийг тодорхойлж болох юм.

Аливаа бараа бүтээгдэхүүнийг тодорхой зах зээлд нийлүүлэхэд нэг талаас тэр зах зээлд нь эрэлт, нөгөө талд нь

тэрхүү эрэлтийг хангахуйц нийлүүлэлт байх ёстой. Иймээс Хятад улсын импортын харьцангуй давуу талын индексийг³ ашиглан зах зээлийн эрэлтийг, Монгол улсын экспортын харьцангуй давуу талын индексийг ашиглан нийлүүлэлтийн боломжийг судалсан. Улмаар импорт, экспортын харьцангуй давуу талын давхцалыг ашиглан БНХАУ-д Монгол улсын нийлүүлэх боломжтой өрсөлдөх чадвар бүхий бараа бүтээгдэхүүний тодорхойлох оролдлого хийсэн болно.

Тодорхой бүтээгдэхүүний хувьд экспортын болон импортын харьцангуй давуу талын индексүүд нь адилхан их, өөрөөр хэлбэл, $RCA_{ij} > 1$, $RMA_{ij} > 1$ байх нөхцөлд тухайн бүтээгдэхүүнийг өөр хоорондоо худалдаалах боломжтой гэж үзсэн. Харин бусад тохиолдолд уг бүтээгдэхүүнийг худалдах боломжгүй.

Дээрх аргачлалыг ашиглан Монгол улсаас экспортлох боломжтой, харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүнийг шүүж үзэхэд БТКУС-ийн 26, 05, 51, 71, 41, 74, 02, 25-р бүлгүүд харьцангуй давуу талтай, 57, 61-р бүлгийн барааны харьцангуй давуу тал алдагдах, 27-р бүлгийн барааны харьцангуй давуу тал сайжрах хандлагатай байсан бөгөөд индексээс харахад 26, 05 бүлгийн барааны хувьд харьцангуй давуу тал өндөр, өрсөлдөх чадвар сайтай байна.

Эдгээр бүлгийн барааны нэр төрлийг нарийвчлан авч үзвэл үхэр болон адууны мах, олон гэдэс, мал амьтны эвэр туурай, жонш, зэс, гянтболд, молибдений хүдэр ба баяжмал, катодын зэс, чулуун нүүрс, тэмээ, үхэр, хонь, ямааны арьс, тэмээ, хонины ноос, үхрийн хөөвөр, ямааны ноолуур, хивс болон малын ноос, ноолууран хувцасны хувьд давуу талтай байлаа.

Монгол улсын экспортын харьцангуй давуу талд хийсэн шинжилгээнээс үзэхэд, харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүний дийлэнх хувийг Рикардогийн бүтээгдэхүүн буюу олборлох үйлдвэрлэл, мал аж ахуйн гаралтай түүхий эд зэрэг байгалийн баялагт түшиглэсэн бүтээгдэхүүн эзэлж байв.

Хятад улсын импортын харьцангуй давуу талын индексээс харахад БТКУС-ийн 97 бүлэг бараанаас 20 орчим нь импортын харьцангуй давуу талтай байгаа ба гол төлөв байгалийн

баялаг, түүхий эд бүхий бүлгүүд байна. Эндээс үзэхэд Хятад улс түүхий эд импортолж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх тал дээр ихээхэн амжилт олсон болох нь харагдаж байна.

БНХАУ-ын импортын харьцангуй давуу талтай барааны бүлэгт Монгол улсын экспортын харьцангуй давуу талтай бараанаас хүдэр, баяжмал (26), зэс (74), ноос, ноолуур (51), арьс шир (41) орж байгаа бөгөөд давхцалыг индексээр нь дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 3. МУ-ын экспортын харьцангуй давуу тал ба БНХАУ-ын импортын харьцангуй давуу тал, сүүлийн 9 жилийн дундаж

МУ-ын экспортын харьцангуй давуу тал өндөр бүлэг	БНХАУ-ын импорт				
	Харьцангуй давуу талтай		Харьцангуй давуу талгүй		
		RMA>2 Маш өндөр	2>RMA>1 Өндөр	1>RMA>0.5 Өндөр	RMA<0.5 Маш өндөр
02 Мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн					(0.2)
05 Мал амьтны гаралтай бүтээгдэхүүн				(0.6)	
25 Давс; хүхэр; шороон эрдэс, чулуу; шаварлаг эрдэс, шохой болон цемент			(1)		
26 Хүдэр, баяжмал, шаараг болон үнс.	(5)				
27 Эрдэс түлш, нефть ба тэдгээрийн бүтээгдэхүүн; битумын эрдэс; эрдэс лав.				(0.8)	
41 Арьс, ширэн түүхий эд (ангийн үснээс бусад) ба боловсруулсан арьс, шир.	(2.8)				
51 Ноос, мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгас; адууны хялгасан ээрмэл, тэдгээрийн нэхмэл даавуу.	(2.7)				
57 Хивс болон нэхмэл дэвсгэр					(0.1)
61 Сүлжмэл хувцас ба хувцасны сүлжмэл тоног хэрэгсэл					(0.1)
71 Үнэт буюу хагас үнэт чулуу, үнэт металл, үнэт металлаар бүрсэн жирийн металл, тэдгээрээр хийсэн зүйлс;					(0.3)
74 Зэс ба түүгээр хийсэн эдлэл	(2.8)				

Дээрх хүснэгтээс харахад Хятад улсад 25, 26, 41, 51, 74-р бүлгийн барааг тус тус экспортлох боломжтой байна. Түүнчлэн Хятад улс эдгээр бүтээгдэхүүний импортоор дэлхийд нэгдүгээр, 27 бүлгээр хоёрдугаар байранд орж байгаагаас үзэхэд эрдэс бүтээгдэхүүн, түүхий эдийн хувьд Хятад улсад эрэлт өндөр байх нь. Харин Монгол улсын экспортын харьцангуй давуу талтай, нэмүү өртөг шингэсэн бараа болох 57, 61 бүлгээр Хятад улс экспортын харьцангуй давуу талтай байна.

Монгол улсын экспортын харьцангуй давуу талтай бүтээгдэхүүн болох түүхий эд, байгалийн баялаг Хятадын импортын харьцангуй давуу талтай ерөнхийдөө давхцаж байгаагаас хоёр орны хоорондох худалдаанд түүхий эдийн худалдаа зонхилох болжээ.

Дээрх нөхцөл байдлаас харахад малын арьс, шир болон үс, ноос, түүнчлэн уул уурхайн хүдэр, баяжмал, зэсийн гол зах зээл нь Хятад улс бөгөөд цаашид БНХАУ-ын импортын харьцангуй давуу тал, Монгол улсын экспортын харьцангуй давуу тал дээр үндэслэн худалдаа хийх нь манай дотоодын зах зээл дээр урт хугацаанд уул уурхайд тулгуурласан боловсруулах үйлдвэрлэлд шаардлагатай стратегийн түүхий эд, мөн арьс шир боловсруулах, ээрмэл, сүлжмэлийн үйлдвэрүүдийн түүхий эдийг худалдан авах өрсөлдөөнийг улам хүчтэй болгож болзошгүй байна.

3. Цаашид хамтран ажиллах чиглэл

Монгол улс далайд шууд гарах гарцгүй, олон улсын хэмжээнд гадаад тээвэрлэлтийн зардлын түвшингээр хамгийн өндөртэйд тооцогддог орнуудын нэг⁴ билээ. Тиймээс тээврийн өндөр өртөг зардал нь Монголын гаралтай барааны өрсөлдөх чадварыг бууруулж, импортолж буй барааны үнийг өндөрсгөж байдаг.

Иймд транзит тээвэрлэлтийн салбарт ДХБ-ын хэлэлцээрийн дагуу үндэсний нөхцөл хэрэглэх болон хоёр талт гэрээ хэлцлийг амжилттай байгуулсан нөхцөлд⁵ хоёр орны хувьд харилцан ашигтай байж болох юм. Тухайлбал, Монгол улс Япон, БНСУ зэрэг орны зах зээлд нүүрс, зэсээ хямд зардлаар гаргахаас гадна БНХАУ нь манай улсын нутаг

дэвсгэрээр дамжин (хамгийн дөт зам) Европын зах зээлд гарах зардлаа бууруулах боломжтой.

Түүнчлэн БНХАУ-тай эрчим хүчний салбарт хамтран ажиллах гэрээ хэлцлийг байгуулан ажиллаж болох юм. Ялангуяа нүүрсний томоохон орд газруудыг түшиглэсэн цахилгаан станцуудыг барьж байгуулан, эрчим хүчээ Хятадын хил орчмын зах зээлд нийлүүлэх боломж бий.

2013 оны 11-р сарын 12-нд ХКН-ын Төв хорооны 3-р бүгд хурлаас батлан гаргасан "Шинэчлэл өөрчлөлтийг тал бүрээр гүнзгийрүүлэх нэн чухал асуудлуудын тухай ХКН-ын төв хорооны шийдвэр"-т "...Худалдааны чөлөөт бүсийг хурдацтай байгуулна. улс орнуудтай худалдааны чөлөөт бүсийн сүлжээг байгуулна..." гэж заажээ. Түүнчлэн Монгол улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөрт "Талууд хоёр улсын хамтын ажиллагааны тодорхой суурь нөхцөл бүрдсэн хил орчмын бүс нутагт хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах боломжийг идэвхтэй эрэлхийлнэ" гэж заасан. Иймээс Цагааннуур болон Алтанбулаг худалдааны чөлөөт бүс, Замын-Үүд Эдийн засгийн чөлөөт бүсүүдэд үр ашигтай хамтран ажиллах, эдгээр бүсийг БНХАУ-ын тухайлбал, "Хоргос" болон бусад бүсүүдтэй сүлжээ үүсгэн ажиллуулах боломж, ач холбогдлыг судалж хэрэгжүүлэх нь зүйтэй болов уу.

Харилцан ашигтай, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх (25, 26, 27, 41, 51, 74, 57, 61-р бүлгийн бараа) чиглэлээр хамтран ажиллах, гуравдагч орны зах зээл дээр хамтран гарах. Түүнчлэн боловсруулсан өнгөт болон хар төмөрлөгийг Хятад улсад нийлүүлэх боломжтой.

Монгол улс хүнсний нийт хэрэглээний 50 гаруй хувийг импортоор хангаж байгаа бөгөөд импортын гурил, цагаан будаа, ногоон цай, хүнсний ногоо, жимс, жимсгэний ихэнх хувийг Хятад улсаас авч байгаа юм. Иймд хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын хяналтыг хамтран хэрэгжүүлэх⁶ шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. Монгол улс, БНХАУ хоорондын Чөлөөт худалдааны хэлэлцээрийн төслийн үндэслэл. – УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2013. – 126х.
2. ХКН-ын Төв хорооны 3-р бүгд хурлаас батлан гаргасан "Шинэчлэл өөрчлөлтийг тал бүрээр гүнзгийрүүлэх нэн чухал асуудлуудын тухай ХКН-ын төв хорооны шийдвэр"
3. Монгол улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр
4. Монгол улсын гаалийн статистик, 1997-2012 он
<http://www.trademap.org>

ЭШЛЭЛ ЗҮҮЛТ

¹ 1990 онд 1584.7 сая ам.дол.

² $RCA_{ij} = RXA_{ij} = (x_{ij}/X_{it}) / (x_{wj}/X_{wt})$ - Revealed comparative advantage or revealed export advantage

³ $RMA_{ij} = (t_{ij}/M_{it}) / (t_{wj}/M_{wt})$ - Revealed import advantage

⁴ Монгол улс гадаад худалдаа эрхлэх индексээр Азийн бүсийн дунджаас 2 дахин доогуур үзүүлэлттэй (180 орноос 156-р байр) гарахад экспорт, импортод зарцуулж буй хугацаа, зардал ихээхэн нөлөөлж байгаа юм.

⁵ Монгол улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөрт "Талууд дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааг идэвхжүүлж, далайд гарцгүй Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүнийг гуравдагч орнуудад экспортлохыг дэмжих бөгөөд 1991 онд байгуулсан "Монгол Улс Хятад Улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг шинэчлэн байгуулах чиглэлээр хамтран ажиллана" гэж заасан.

⁶ Дээрх хөтөлбөрт "Талууд гааль, чанарын хяналт шалгалт зэрэг байгууллагын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах болон амьтан, ургамлын хорио цээрийн хамтын ажиллагааны механизмыг боловсронгуй болгож, бэхжүүлнэ" гэж заасан.